



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№240 /449/ 2022.01.05

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

ЭЛЧИН САЙД РИЧАРД БУАНГАНЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ноён Ричард Буанганыг өнөөдөр хүлээн авч уулзлаа.

Тус уулзалтаар Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Элчин сайд ноён Ричард Буанган болон тус Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе дэд хурандаа Бриан Харт нарт баяр хүргээд хоёр улсын харилцаа, тэр дундаа батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиглэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцов.

Мөн цаашид хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, илүү олон чиглэлд хамтарч ажиллахаа мэдэгдлээ.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-15	-27


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
35	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.465	3.472
EUR	3.690	3.710
CNY	501.50	504
RUB	46	47.20
JPY	26.20	26.50
KRW	2.75	2.77

ЗУРХАЙ



2022.01.05 / ПҮРЭВ ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 14

**ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА
САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ
ХАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР**

Үс засуулбал:
Эд мал арвидна
Наран ургах, шингэх:
08.41-17.13
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Хуран үйлдэхүй

ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН НЭГЖҮҮДИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БҮРЭН БИЕЛЖЭЭ

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албанаас Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хяналт шалгалтын нэгжүүдийн нэгдсэн тайланг дүгнэн 2023 оны төлөвлөгөөг танилцуулах хурлыг зохион байгууллаа.

Өнгөрсөн онд тус нэгжүүд нь нэгдсэн байдлаар 4 зорилтын хүрээнд нийт 28 ажил төлөвлөсөн бөгөөд эдгээр ажлууд бүрэн биелжээ. Тухайлбал, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын хээрийн гаралтын бэлтгэл сургуулилын үеэр холбогдох үүрэг чиглэлийг өгч салбарын хэмжээнд цахим хяналт, шалгалтын нэгдсэн мэдээллийн сангийн программтай болсон төдийгүй цахим нөлөөллийн аян, сэтгэл зүй, ёс суртахуун харилцаа хандлага, төлөвшил, хувь хүний хөгжил манлайллын талаарх сургалтыг тус тус зохион байгуулсан байна.



Мөн Хүний эрхийн үндэсний комисстой 2022-2024 он хүртэл хамтран ажиллах санамж бичиг байгуулж цэргийн алба хаагчдынхаа эрх ашгийг хамгаалах талаар тодорхой ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж буй аж.

Энэ үеэр Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар хяналт шалгалтын нэгжүүд нь харилцан санал солилцож, ажлын төлөвлөгөөг нэгдсэн байдлаар гаргадаг болсон. Ингэснээр ажлын давхцал, хүнд

суртал арилах, нэгжүүдийн ажлын уялдаа холбоо сайжирч шалган турлах, зөвлөх ажил нэлээд үр дүнд хүрч байгааг онцоллоо.

Харин ирэх онд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хяналт шалгалтын нэгжүүд нь улсын дайчилгаа, цэргийн дайчилгааны орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийн баримт бичигт үнэлэлт дүгнэлт хийх, дотоод хяналт шалгалтыг улам сайжруулж эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр танхимын сургалт зохион байгуулах төдийгүй цахим нөлөөллийн аянд БХЯ-ны харьяа байгууллагууд, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлалуудыг татан оролцуулахаар төлөвлөдөг байгаа аж.

ХУМХАА ӨВЧНИЙ ХАЛДВАР АВСАН ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ХИЙЛЭЭ



Өмнөд Судан Улсад үүрэг гүйцэтгэсэн цэргийн алба хаагч хумхаа өвчний улмаас таалал төгссөнтэй холбогдуулан Батлан хамгаалах яамнаас хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж мэдээлэл өглөө. Хурлын эхэнд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар Монгол Улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд хэрхэн оролцож байгаа болон үүсээд буй нөхцөл байдлын талаар товч мэдээллийг өгсөн юм.

Үргэлжлүүлэн, Цэргийн төв эмнэлгийн дарга-Ерөнхий эмч хурандаа Б.Энх-Од хумхаагийн өвчлөл хийгээд тус өвчний халдвар авсан цэргийн

алба хаагчдын талаар мэдээлэл өгсөн юм. Тэрээр хэлэхдээ "НҮБ-ын мандаттайгаар Африкийн орнуудад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагчидтай I, II шатны цэргийн хээрийн эмнэлгүүд мөн үүрэг гүйцэтгэдэг. Африкийн орнуудад өргөн тархалттай байдаг хумхаа хэмээх өвчний талаарх ойлголтыг өгье. Судалгаанаас авч үзвэл, тус улсын 10 шумуулын нэг нь хумхаа өвчний вирусийг тээдэг. Өөрөөр хэлбэл зөвхөн шумуулнаас хүнд дамждаг халдварт өвчин гэсэн үг. Борооны улирлын эхэн болон сүүл үед ихээхэн идэвхждэг. Хумхаагийн вакцин гараагүй учраас манай цэргийн алба хаагчид уг өвчнөөс

урьдчилан сэргийлэх эмийг долоо хоног тутамд хэрэглэдэг. Эмээ тогтмол уусан ч тухайн хүнд уг өвчний вирус халдварлах боломжтой. Гагцхүү хүнд, хөнгөн хэлбэрээр өвчлөх нь тухайн хүний биеийн эсэргүүцэлтэй холбоотой.

Өнгөрөгч сард эх орондоо ирсэн цэргийн багийн есөн алба хаагчаас хумхаа өвчин илэрч Цэргийн төв эмнэлэгт хүргэгдсэнээс долоо нь бүрэн эдгэрсэн. Харамсалтай нь нэг цэргийн алба хаагч энэ өвчний хүндрэлээр нас барсан. Харин нөгөө нь Цэргийн төв эмнэлгийн Эрчимт эмчилгээний тасагт биеийн байдал нэн хүнд байдалтай хэвтэн эмчлүүлж байна" гэлээ.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 666,864,479

Эдгэрсэн

Нийт: 638,581,519

Нас барсан

Нийт: 6,704,188

СПОРТ ЗААЛ, БЯЛДАРЖУУЛАХ ТӨВТЭЙ БОЛОВ



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги офицер, ахлагч, ажилтан албан хаагчид, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдынхаа эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг дээшлүүлэх зорилгоор спорт заал, бялдаржуулах төвийг шинээр ашиглалтад орууллаа.

Үйл ажиллагааг нээж тус ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Ц.Гантулга хэлсэн үгэндээ, “Бид бүхэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан “Эрүүл монгол хүн” хөтөлбөр, ангийн 2022-2023 оны

сургуулийн жилийн сургалт, бэлтгэлийн зорилго, зорилтын хүрээнд тус спорт заалыг өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан засварлаж өнөөдөр ийнхүү ашиглалтад өгч байна. Эл спорт заал, бялдаржуулах төвийг ашиглалтад оруулснаар ангийн бие бүрэлдэхүүн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэнд, бие бялдрынхаа өв тэгш хүмүүжилд анхаарч эрүүл монгол хүн байх үндэс суурь тавигдах төдийгүй эндээс ирээдүйд спортын мастер, аваргууд олон арваараа төрөн гарна гэж найдаж байна. Энэхүү засвар тохижилтын ажлыг өрнүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэн хамтарч ажилласан

ЗХЖШ, ХЗЦК-ын удирдлага, бие бүрэлдэхүүн болон гар бие оролцсон нийт алба хаагчдадаа ангийнхаа бие бүрэлдэхүүний өмнөөс талархал илэрхийлье” гэлээ.

Үргэлжлүүлэн ЗХЖШ-ын Сургалт, бэлтгэлийн газрын БТСТ-ийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ хэлсэн үгэндээ өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан энэ хэмжээний бүтээн байгуулалтыг хийж чадсан тус ангийн хамт олон, удирдлагуудаар бахархаж буйгаа онцлоод 2023 ондоо амжилт бүтээлээр дүүрэн, эрч хүчтэй, эрүүл чийрэг хамт олон байхыг хүсэн ерөөсөн

юм.

Энэ үеэр спорт заал, бялдаржуулах төвийн жаврыг үргээж тус ангийн байлдагч Б.Батхишиг морин хуурын татлагаар хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдөд мэндчилгээ дэвшүүлэв.

Уг ёслолын ажиллагаанд ЗХЖШ-ын Сургалт, бэлтгэлийн газрын БТСТ-ийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ, тус ангийн ахмад дайчин бэлтгэл хурандаа Т.Жаргалсайхан, ангийн удирдлага, бие бүрэлдэхүүний төлөөлөл оролцсон юм.

"БАЙЛДАГЧИЙН НАЙЗ ОХИН БАЙНА ГЭДЭГ БАХАРХАЛТАЙ САНАГДДАГ"



Өнөөдөр нийгмийн сүлжээнд залуус сонирхол, ажил мэргэжил, хүсэл зорилгоороо нэгдэж ярилцах, мэдээллээ хуваалцах болсон билээ. Мэдээллийн урсгалаас хамаараад тэр нь хүнд, хөнгөн янз бүр.

Тэр олон мянган фейсбүүк групп дундаас хөнгөн бөгөөд мэдээллийн урсгал нь дэндүү эерэг нэгэн цахим хуудас олов. “Би байлдагчийн найз охин” гэсэн нэртэй. Орж үзлээ, Үндсэн хуулиар хүлээсэн үндсэн үүргээ гүйцэтгэж байгаа эр цэргүүдээр бахархсан найз охидын пост, сэтгэгдэл, зураг, бичлэг дүүрэн.

Манай цэргийн дарга нар “Олон нийтэд хугацаат цэргүүдийг сурталчилсан мэдээлэл, нийтлэл бич” гэж байнга үүрэгддэг сэн. Тэнд харин яг өөрөөрөө, ямар нэгэн хүний нөлөөлөлгүйгээр эр цэргийн албаны сайхныг нэгэндээ магтаж, зарим нь асуулт зөвлөгөө авч, хамтын зураг бичлэгт нь лайк, зүрх дарахыг уриалж. Сошиал сүлжээнд эерэг мэдээлэл түгээгч “Би байлдагчийн найз охин” фейсбүүк группийн админ Г.Мөнхжаргалтай ярилцлаа. Тэр

мэдээж бэлтгэл үүрэгтний гэргий бөгөөд түүний хань Э.Ган-Эрдэнэ 2020-2021 онд “Хээрийн академи” нэрээрээ алдаршсан Зэвсэгт хүчний 336 дугаар ангид хугацаат цэргийн алба хаажээ.

“Би байлдагчийн найз охин” цахим групп нь хөнгөн мэдээллээр дүүрэн юм. Нээх болсон шалтгаанаасаа хуваалцахгүй юу?

“Анх энэ группийг нээх болсон нь түүхтэй л дээ. 2020 оны хоёрдугаар ээлжээр найз залуугаа хугацаат цэргийн албанд мордуулах шийдвэрийг бид ярилцаж гаргасан байлаа, өмнө нь. Тэр маань ямар нэгэн шалтаг шалтгаан хэлж, “бултаж” үлдэх сонирхолгүй, явах дуртай. Тэгээд бидний хүсэн хүлээсэн цэрэг татлага эхэлсэн чинь Э.Ган-Эрдэнэд зарлан нь ирдэггүй. Өөрсдөө Орхон аймгийнхаа ЗДТГ-ын Цэргийн штабт гүйж очиж учир байдлаа хэлж зарлан дуудах хуудсаа авсан. Цэргийн штабын дарга, дэд хурандаа Б.Оюунтүлхүүр гэдэг дарга “Эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ ухамсарласан ийм зорилготой

хөвгүүдийг бид дэмжинэ, олон ч залуу өөрсдөө ингэж ирдэг” гээд биднээс ч илүү баярлахихсан гардуулж өгсөн юм даг. Тэгж л манай хүн Зэвсэгт хүчний 336 дугаар ангид хуваарилагдаж, эр цэргийн албандаа мордсон бөгөөд хайрыгаа цэргийн автомашиндаа сууж байх үеийг бичлэг болгон авч үлдсэн юм. Хайрыгаа санахаараа бичлэгээ үздэг байснаа яагаад хүмүүст хүргэж болохгүй гэж бодоод сошиал хуудастаа оруулав.

Маш олон хүн дэмжиж, урам хайрласан. Үүнээс л урамшиж хувийнхаа цахим хуудастаа хайрыгаа хүлээсэн 365 хоногт олон сайхан бичлэг бэлтгэн оруулсан.

Цэргийн хуарангаас ирсэн захидлыг нь задалж, цэргийн албанд очсоноор хэрхэн өөрчлөгдөж төлөвшсөн талаар сэтгэгдлээ хуваалцаад л. Хүлээхийн жаргал гэж байдгийг л харуулахыг зорьсон нь тэр. Тэгээд найз залуу минь ч халагдаж ирлээ. Гэсэн ч охиноос “Манай найз цэрэгт явах гэж байна. Би бас тань найз залуугаараа ингэж бахархмаар байна” гэж хандсан болохоор “Би байлдагчийн найз охин” нэртэй фейсбүүк групп нээсэн юм. Одоо энэ хаалттай группт цэрэг мордсон залуу бүрийн гэргий, найз охид зэргэлт болон цахимаар ярилцсан бичлэг, зургаасаа хуваалцаж, нэгэндээ урам өгдөг.

“Таны найз залуу цэрэгт явснаар ямар эерэг өөрчлөлт авчирсан гэж хэлэх вэ?”

“Тооцоод баршгүй. Хоёр гол чанарыг нь дурдахад, нэгдүгээрт хувийн зохион байгуулалт, цаг төлөвлөлт, эмх цэгцгийг бат суулгаж өгдөг юм билээ. “Одоо бид тэгэх ёстой, тэгэхийн тулд ийм алхам дуутуу байна” гээд ажил, амьдралаа бүрэн төлөвлөж хэвшсэн нь маш их таалагдаж байгаа.

Хоёрдугаар чанар нь илүү их төлөвшиж, шийдвэр гаргахдаа зоригтой болсон байна лээ. Хөлж байгаа үг, хийж байгаа үйлдэл, санан сэдэж байгаа бодол нь хүртэл өөр. Сурсан мэдсэн зүйл ихтэй, бахархах ч зүйл ихтэй. Би хүүхдээ цэрэгт явуулахгүй гэдэг хүмүүсийг их гайхдаг. Хүүгийнхээ, найз залуугийнхаа бахархал, омогшилтой амьдралынх нь сайхан

дурсамжийг үгүй хийж байгаа юм шиг санагддаг.

“Та хоёрын цаашдын хүсэл мөрөөдлөөс хуваалцвал?”

“Бид Эрдэнэт хотод амьдардаг, удахгүй аав, ээж болно. Аав, ээж болох бэлтгэлээ хангаад завгүй л явна. Ганаа маань халагдаж ирээд “Эрдэнэт Мах Маркет” компанийн борлуулалтын албанд ажиллаж байна. Дарга нь “Танай хүн цэрэгт

явсан нь мэдэгддэг шүү. За гэвэл ёогүй. Ажлыг цаг хугацаанд гүйцэтгэж, хамт олонтойгоо нийтэч, зөв сайханд үргэлж уриалсан залуу” гэж магтдаг юм. Би фейсбүүк групп дахь байлдагч нарынхаа найз охидод хайртыгаа цэргийн албатай нь хамт хайрлаж, хүндэлж яваарай гэж уриалдаг даа.

Ахмад Д.БОЛОР

Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №51

ША ҮСГИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ
ША бол дэвсгэр бус үсэг. Бүтэц зурлагын хувьд өмнө үзсэн СА үсгийн адил “завьж”-т үсэг болой. Нэмэлт зурлага хоёр дуслар ялгадаг. Завьж зурлагыг үзгээ салгалгүй бичиж төгсгөх бөгөөд нурууны шугам дагуу үсэг үеүдээ бичиж гүйцсэний дараа үзгээ салган завьжны баруун дор нь хоёр дуслыг бичдэг. Уншигч та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд ордог ША, ШЭ, ШИ, ШО, ШУ, ШӨ, ШҮ гэж аялгуулан дуудаж үе үсэг хэрхэн хувирч буйг нүдлэн тогтоогоорой. Монгол хэлнээ СИ гэсэн үг байдаггүй, ШИ үе байдаг гэж өмнө үзсэн билээ. Тиймээс ШИ-г бичихдээ хоёр дусалгүй СИ гэж бичиж зурлага хэмнэдэг учиртай.

Бичмэл тигээр:

